

ДААТГАЛЫН ИЖ БҮРДЭЛ СОНГОХ



ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЭХ ҮНДСЭН ИЖ БҮРДЭЛ

Тус иж бүрдэлд дотоодын болон Азийн сүлжээ эмнэлгүүдэд хэвтэн эмчлүүлэхтэй холбоотой эмчилгээ үйлчилгээнүүд багтана. Үүнд:

- 2 болон түүнээс дээш ортой өрөөний төлбөр
- Архаг эмгэгийн менежмент
- Мэс засал, эрчимт эмчилгээ
- Эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал
- Дүрс оношилгоо (СТ, MRI, ЭКГ, ЭХО г.м)
- Лабораторийн шинжилгээ
- Жорын дагуух эм

* Хэвтэн эмчлүүлэх үндсэн иж бүрдлийг авснаар нэмэлт иж бүрдлүүдээс сонгох боломжтой.



АМБУЛАТОРИЙН ЭМЧИЛГЭЭ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ИЖ БҮРДЭЛ

Тус иж бүрдэлд дотоодын болон Азийн сүлжээ эмнэлгүүдээс амбулаторийн эмчилгээ үйлчилгээ авахтай холбоотой дараах үйлчилгээнүүд багтана. Үүнд:

- Эмчийн үзлэг, эмчилгээ
- Өдрийн эмчилгээ
- Дүрс оношилгоо (СТ, MRI, ЭКГ, ЭХО г.м)
- Лабораторийн шинжилгээ
- Жижиг мэс ажилбар



ЖИРЭМСЛЭЛТ, ТӨРӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ИЖ БҮРДЭЛ

Тус иж бүрдэлд жирэмслэлт, төрөлт, жирэмсний хүндрэлтэй холбоотой эмчилгээ, үйлчилгээнүүд багтана.

Жирэмслэлт, төрөлтийн иж бүрдлийг сонгон даатгуулснаас хойш 24 сарын дараа идэвхэжнэ.



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БАГЦ ШИНЖИЛГЭЭ

Жаргалан Эрүүл Мэндийн Даатгалын сүлжээ хувийн эмнэлгүүдэд урьдчилан сэргийлэх багц шинжилгээнд хамрагдах боломжтой.

Санамж: Даатгалын үнэлгээ буюу нөхөн төлбөр олгох хамгаалалтын дээд хэмжээ нь эмчилгээ, үйлчилгээний төрөл бүрээр харилцан адилгүй болохыг анхаарна уу.

ХЭРХЭН ДААТГУУЛАХ ВЭ?



I Мэдээлэл, зөвлөгөө авах

Даатгуулагч Мандал Даатгалын лавлах төвтэй **75752000** дугаараар холбогдож эсвэл Мандал Даатгалын төв оффист ирж дэлгэрэнгүй мэдээлэл, зөвлөгөө авна.



II Өргөдлийн маягт бөглөх

Даатгуулагч эрүүл мэндийн даатгалын өргөдлийн маягт, эрүүл мэндийн асуумжыг бөглөж ирүүлнэ.



III Даатгах эсэх шийдвэр гарах

Даатгагч нь хүлээн авсан эрүүл мэндийн даатгалын өргөдлийн маягт, эрүүл мэндийн асуумжыг үнэлэн, ямар нөхцөлөөр даатгалд хамруулах талаар Даатгуулагчид хариу мэдэгдэнэ.



IV Даатгалын гэрээ байгуулах

Даатгуулагч даатгалын багц, хамгаалалтын иж бүрдлээ сонгож даатгалын гэрээ байгуулан, хураамжаа төлснөөр даатгал идэвхэжнэ.

МОНГОЛ ДАХЬ СҮЛЖЭЭ ЭМНЭЛГҮҮД



Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-24, Паркплейс барилга, 1-р давхар

И-мэйл: Info@mandal.mn
Вэб: www.mandal.mn

Мэдээлэл лавлагааны төв
7575 2000

f t in o /MandalDaatgal



2019M01



Аз жаргалаа дархлав

ЖАРГАЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ
ХЭРЭГЦЭЭНД НИЙЦСЭН • ИЖ БҮРЭН • ХУВИЙН

ЭРҮҮЛ МЭНД ЭРХЭМ БАЯН

ТАНЫ ЭРҮҮЛ МЭНД НАЙДВАРТАЙ ГАРТ



ЖАРГАЛАН Эрүүл Мэндийн Даатгал нь **Монголын №1** сайн дурын эрүүл мэндийн даатгал бөгөөд зах зээлийн **70%** дангаараа бүрдүүлж байна.

Хэрэглэгч та ЖАРГАЛАН Эрүүл Мэндийн Даатгалыг сонгосноор бүхий л төрлийн эмчилгээ үйлчилгээг Монгол улсын тэргүүлэх хувийн болон улсын эмнэлгүүд, цаашлаад Азийн нэр хүндтэй эмнэлгүүдээс авах боломжтой.

Хөгжиж буй орны хувьд даатгалын үйлчилгээний найдвартай байдлыг хангахад давхар даатгагчийн үүрэг оролцоо өндөр байдаг. Тэр ч утгаараа ЖАРГАЛАН Эрүүл Мэндийн Даатгал нь Англи улсад төвтэй Олон Улсын Эрүүл Мэндийн даатгагч ЛАМП групп компаниар давхар даатгагдсан гэдгийг сонордуулахад таатай байна.

ЖАРГАЛАН Эрүүл Мэндийн Даатгал нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад суурилсан өөр өөрийн онцлогтой багцуудаас бүрдсэн бөгөөд хэрэглэгч өөрийн сонгосон багцаас хамаарч нэг жилийн хугацаанд Монгол болон Ази дахь олон улсын стандартад нийцсэн сүлжээ эмнэлгүүдээс хамгаалалтын дээд хэмжээ хүртэл эмчилгээ үйлчилгээ авах боломжтой.

Эрхэм хэрэглэгч танд, өөрийн болон гэр бүлийнхээ эрүүл мэндийг зах зээлийн хамгийн бага үнээр даатгуулан, эрүүл мэнд, аз жаргалдаа хөрөнгө оруулах сонголтыг Мандал Даатгалын хамт олноос ЖАРГАЛАН Эрүүл Мэндийн Даатгалаараа дамжуулан санал болгож байна.

БИД ХЭН БЭ?

МАНДАЛ ДААТГАЛ ХК



Мандал Даатгал ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан ердийн даатгалын компани бөгөөд тасралтгүй өсөлтийг үзүүлсээр 2016 онд салбарын ТОП 3 даатгалын компанийн нэг болж чадсан. 2018 онд Монголын Хөрөнгийн Бирж дээр хувьцаагаа арилжаалж нээлттэй компани болж өргөжсөнөөр санхүүгийн болон бусад үзүүлэлтээр даатгалын салбарт тэргүүлэгч байр суурийг эзэлсэн амжилттай байна.

ЖАРГАЛАНГ СОНГОХ ШАЛТГААН



Өндөр үнэтэй эмчилгээний зардлууд багтсан /Эд, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал гэх мэт/



Монголын тэргүүлэх хувийн болон улсын эмнэлгүүдийг өөрийн эмнэлгийн сүлжээнд багтаасан



Хэвтэн эмчлүүлэх тохиолдолд төлбөрийг эмнэлэг рүү шууд шилжүүлэх



Англи улсад төвтэй олон улсын эрүүл мэндийн даатгагч ЛАМП групп компаниар давхар даатгагдсан



Архаг эмгэгийн менежментийн 5,000,000₮ хүртэл хамгаалалт



Даатгуулагч өөрт тохирсон эрүүл мэндийн даатгалын багц болон иж бүрдлийг сонгох боломж



Мэргэшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс бүрдсэн эрүүл мэндийн даатгалын тусгайлсан алба



Эрүүл мэндийн даатгалын лавлах үйлчилгээ



Даатгалын хураамжийг 12 сар хүртэл хугацаанд хуваан төлж төлбөрийн ачааллыг бууруулах


ДААТГАЛЫН БАГЦ

ҮНДСЭН БАГЦ



Монгол улсын тэргүүлэх хувийн эмнэлгүүд болон улсын бүх шатлалын эмнэлгүүдэд **50,000,000₮** хүртэлх үнийн дүн бүхий эмчилгээ, үйлчилгээг авах боломжтой.

АЗИ БАГЦ



ҮНДСЭН багцад хамаарах бүх иж бүрдлүүдийн эмчилгээ, үйлчилгээ хамгаалалтын дээд хэмжээ хүртэл хамрагдахаас гадна Тайландын Бумрунград зэрэг Азийн тэргүүлэх олон улсын ангиллын эмнэлгүүдэд **250,000\$** хүртэлх үнийн дүн бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг авах боломжтой.

ПЛАС 30 БАГЦ



- + Хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал
- + Урьдчилан сэргийлэх шинжилгээний иж бүрдэл

ПЛАС 30 багц нь эмчилгээний зардал болон гэнэтийн ослын хамгаалалттай бөгөөд нэмэлтээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамрагдах боломжийг нэг дор олгож буй цогц даатгал юм.